



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 12.

Улаанбаатар хот

Г Дотоод аудитын дүнгийн тухай Г

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 3.6, 4.1.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан удирдамжийн хүрээнд Говь-Алтай аймаг дахь Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2017, 2018 он, 2019 оны нэгдүгээр улирлын төсвийн төлөвлөлт, зарцуулалт үр дүн, тайлагналт, төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнг хэлэлцээд дотоод аудитын хорооны хурлаас ТОГТООХ нь:

1 Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2017, 2018 он, 2019 оны нэгдүгээр улирлын төсвийн төлөвлөлт, зарцуулалт үр дүн, тайлагналт, төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүгнэлт, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны дарга С.Жаргалзаяа, нягтлан бодогч Ш.Ганчимэг нарт үүрэг болгосугай.

3. Дотоод аудитын ажлын тайлан, Дотоод аудитын хорооны тогтоолыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, Дотоод аудитын хорооны хуралд үр дүнг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга В.Жавзанд даалгасугай.

ХОРООНЫ ДАРГА



Н.ЦЭРЭНБАТ

Дотоод аудитын хорооны 2019 оны
06 дугаар сарын 26 ны өдрийн
...12 дугаар тогтоолын хавсралт

ХҮЙСИЙН ГОВЬ-ЦЭЦЭГ НУУРЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА С.ЖАРГАЛЗАЯА, НЯГТЛАН БОДОГЧ Ш.ГАНЧИМЭГ НАРТ

1. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах заалтыг хэрэгжүүлж зардлын гүйцэтгэлийг төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар зөв бүртгэж зарцуулах, цаашид харилцагч нэг бүрээр тооцооны данс үүсгэн өглөг, авлагын журналд ажил гүйлгээг бүрэн тусгаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах;
2. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох заалтыг хэрэгжүүлж орон тоог батлагдсан хэмжээнд ажиллуулах, цалингийн сангийн тооцооллыг нарийвчлан гаргах, ажилтнуудын албан тушаалын ангилал, зэрэглэлийг зөв тогтоож цалинжуулах, хавсран ажиллаж буй ажилтнуудыг тухайн албан тушаалын цалингаас нэмэгдлийг тооцож олгох;
3. Тус сав газрын захиргааны албан хаагчдын ээлжийн амралтын цалингийн бүрэлдэхүүнд унаа, хоолны хөнгөлөлт зэрэг нөхөх олговрыг оруулж тооцон 7 ажилтанд 47.2 мянган төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно гэсэн заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын “Дундаж цалин хөлс тодорхойлох” журмын 4 –т заасныг тус тус зөрчсөн тул цалингаас суутган тооцох;
4. Зардлын хэмжээ тогтоох тухай Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 301 дүгээр тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаж дотоод албан томилолтын хуудсыг дугаарлаж бүртгэлжүүлэх, хоногийн тооцооллыг зөв тооцоолж хэвших;
5. Сургалт олон нийт, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (бичиг хэрэг) Ш.Наранцэцгийн албан тушаалын ангилал зэрэглэлийг Засгийн газрын төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019 оны 24 дүгээр тогтоолын дагуу зөв тооцож олгох, илүү олгосон зардлыг нөхөн төлүүлэх;
6. Дансанд бүртгэлтэй эвдэрсэн, гэмтсэн, ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Өмч хамгаалах байнгын зөвлөлд саналаа хүргүүлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар шийдвэрлүүлэх, ашиглаж байгаа бараа материалыг үнэ цэнийн бууралт тооцох зэрэг арга хэмжээ авах, тооллогын тооцоог бодож хэвших;
7. Сэлбэг хэрэгслийг худалдан авахдаа Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн худалдан авах;
8. Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах дахин давтахгүйгээр арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн сахилга бат, хууль тогтоомжийг чанд сахин мөрдөх;

9. Дотоод аудитын хорооны өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нягтлан бодогчид хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон ажиллах

10. Монгол улсын Улсын Их Хурлын 2016 оны 47, 2017 оны 29, Засгийн газрын 2002 оны 200, 2014 оны 147 дугаар тогтоолууд болон “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг биелүүлэн ажиллаж байгууллагын санхүүгийн сахилга батыг сайжруулан, өгсөн зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж зөвлөмжийн биелэлтийг албан бичгээр 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх, ирүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон ажиллахыг зөвлөж байна.

ДОТООД АУДИТЫН ХОРОО